



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
РЕКТОРЫН ТУШААЛ

2025 оны 11 сарын 06 өдөр

Дугаар А/527

Улаанбаатар хот

МУИС-ийн судалгааны санхүүжилтийн
журам батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.9 дэх хэсэг, 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь хэсэг, МУИС-ийн Дүрмийн 5.4.1, 5.4.8.5 дахь хэсэг, МУИС-ийн Ректорын зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Их сургуулийн судалгааны санхүүжилтийн журмыг хавсралтаар баталж, 2025 оны 10 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2. Монгол Улсын Их сургуулийн судалгааны санхүүжилтийн журам шинэчлэн батлагдсантай холбогдуулан Захирлын 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн А/270 дугаар тушаалаар батлагдсан "МУИС-ийн судалгааны санхүүжүүлтийн журам"-ыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Монгол Улсын Их сургуулийн судалгааны санхүүжилтийн журмыг МУИС-ийн цахим хуудсанд байршуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Судалгаа, хөгжүүлэлтийн газрын дарга (Н.Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Судалгаа, хамтын ажиллагаа эрхэлсэн проректор (С.Гомбобаатар), Төлөвлөлт, хөрөнгө оруулалт эрхэлсэн проректор (Б.Даваасүрэн), Ахисан түвшний сургуулийн захирал (Ц.Амартайван) нарт тус тус даалгасугай.

РЕКТОР



Б.ОЧИРХУЯГ

1425064610

Монгол улсын их сургуулийн ректорын
2025... оны 11 сарын 16-ний/ны өдрийн
А/52.7 тоот тушаалын хавсралт



МУИС-ИЙН СУДАЛГААНЫ САНХҮҮЖИЛТИЙН ЖУРАМ

НЭГ. Ерөнхий зүйл

- 1.1 Энэхүү журмын зорилго нь “МУИС-ийн стратеги төлөвлөгөө 2025–2030”-г хэрэгжүүлэх, үндэсний болон дэлхийн түвшний судалгааны их сургууль болон хөгжих, олон улсын эрэмбийг ахиулах, судалгааны үр дүнг эдийн засгийн эргэлтэд оруулах, профессор багш, судлаач, суралцагчдын судалгаа, инновацын үйл ажиллагааг дэмжих, эрдэм шинжилгээний бүтээлийн тоо, чанар, гадаад ба дотоод хамтын ажиллагааг нэмэгдүүлэхэд оршино.
- 1.2 Журмыг Монгол Улсын Дээд боловсролын тухай хууль, Шинжлэх ухаан технологийн тухай хууль, Судалгааны их сургуулийн эрх зүйн байдлын тухай хууль, Оюуны өмчийн тухай хууль, Инновацын тухай хууль, МУИС-ийн холбогдох дүрэм, журам болон бусад эрх зүйн баримт бичгүүд, мөн энэ журмын нэгдүгээр хавсралтыг дагаж мөрдөнө.
- 1.3 Санхүүжилтийг судалгааны зардал болон төсөл гэсэн хоёр хэлбэрээр олгоно.
 - 1.3.1 Судалгааны зардал нь судалгааны суурь, хувьсах болон судалгааны лабораторийн суурь зардал хэлбэртэй байна.
 - 1.3.2 Судалгааны төслийн санхүүжилтийг нээлттэй сонгон шалгаруулалт, өрсөлдөөний зарчимд тулгуурлан олгоно.
- 1.4 МУИС-ийн үндсэн орон тооны профессор, дэд профессор, докторын зэрэгтэй ахлах багш, багш, докторын зэрэгтэй эрдэм шинжилгээний ажилтан төслийн санал мэдүүлнэ.
- 1.5 Шинжлэх ухаан технологийн сан, Азийн судалгааны сан, МУИС-ийн захиалгат болон дотоодын санхүүжилттэй төслийн гэрээний үүргээ биелүүлээгүй төслийн удирдагч, гүйцэтгэгч, судлаач төслийн сонгон шалгаруулалтад өрсөлдөхгүй.
- 1.6 Азийн судалгааны сангийн санхүүжилттэй төслийг МУИС-ийн дотоод төсөлд хамааруулан тооцно. Иймд тухайн төслийг МУИС-ийн санхүүжилттэй бусад төсөлтэй давхардуулан санхүүжүүлэхгүй.
- 1.7 МУИС-ийн бүрэлдэхүүн/салбар сургууль бие дааж дотоод төсөл зарлаж, шалгаруулах тохиолдолд мөн төслийн менежмент, мэдээллийн систем (цаашид “ТММС” гэх)-д бүртгүүлнэ.
- 1.8 МУИС нь дараах судалгааны зардал болон төслийг санхүүжүүлнэ. Үүнд:
 - 1.8.1 судалгааны зардал;
 - 1.8.2 залуу судлаачийн төсөл;
 - 1.8.3 суурь, хэрэглээний судалгааны төсөл
 - 1.8.4 өндөр түвшний судалгааны төсөл;
 - 1.8.5 инновацын төсөл;
 - 1.8.6 зочин судлаачийн төсөл;
 - 1.8.7 бодлогын судалгааны төсөл.

- 1.9 МУИС-аас санхүүжиж байгаа судалгааны зардал болон судалгааны төслийн санхүүжилтийн хэмжээг МУИС-ийн захиргааны зөвлөлөөс жил бүр шинэчлэн тогтооно.

ХОЁР. Журмын нэр томьёо

- 2.1 Энэхүү журамд хэрэглэсэн нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно.

- 2.1.1 “Судалгаа” гэж шинэ мэдлэг, онол арга зүй, хэрэглээ инновацыг шинжлэх ухааны үндэслэл, нотолгоотойгоор бий болгох, хөгжүүлэх, турших, хэрэглээнд нэвтрүүлэхэд чиглэсэн суурь ба хэрэглээний агуулгатай эрдмийн үйл ажиллагааг;
- 2.1.2 “Судалгааны үр дүн” гэж судалгааны үйл ажиллагааны хүрээнд бий болсон шинэ мэдлэг, онол арга зүй болон хэрэглээ, байгаль, нийгэм, хүмүүнлэг, техник технологийн шийдлийг;
- 2.1.3 “Судалгааны зардал” гэдэгт судалгааны суурь зардал, хувьсах зардал болон судалгааны лабораторийн суурь зардлыг;
- 2.1.4 “Судалгааны суурь зардал” гэж МУИС-ийн профессор, дэд профессор, ахлах багш, багшийн зэрэглэлд ажиллаж байгаа докторын зэрэгтэй үндсэн орон тооны багш нарын судалгааны үйл ажиллагааг дэмжих зорилгоор олгох санхүүжилтийг;
- 2.1.5 “Судалгааны хувьсах зардал” гэж ахисан түвшний суралцагчдын эрдэм шинжилгээний ажлыг дэмжих зорилгоор удирдагч багшийн удирдаж хамгаалуулсан суралцагчдын тоо, тэдгээрийн эрдэм шинжилгээний ажлын чанарын үзүүлэлтийг харгалзан тооцож олгох санхүүжилтийг;
- 2.1.6 “Лабораторийн суурь зардал” гэж МУИС-ийн судалгааны лабораторийн өдөр тутмын үйл ажиллагааг дэмжих зорилгоор олгож буй санхүүжилтийг;
- 2.1.7 “Залуу судлаачийн төсөл” гэж залуу судлаачдад судалгааны ажил хийх дадал төлөвшүүлэх, судалгааны ажлын үр дүнгээ JCR импакт фактор бүхий WoS, Scopus-т бүртгэлтэй олон улсын мэргэжлийн сэтгүүл, Scopus-т бүртгэлтэй бүтээл хэвлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, судалгааны төсөл хэрэгжүүлэх зорилгоор МУИС-ийн үндсэн орон тооны багшид олгох төслийг;
- 2.1.8 “Суурь, хэрэглээний судалгааны төсөл” гэж шинжлэх ухааны онол, хэрэглээний арга зүйд тулгуурлан судалгааг гүйцэтгэж, судалгааны ажлын үр дүнг WoS, эсвэл Scopus-т бүртгэлтэй олон улсын мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлэх, эсвэл үр дүнг практикт нэвтрүүлж бодит хэрэглээнд ашиглан МУИС-ийн нэр дээр дотоодын оюуны өмчийн эрх, патент авах зорилго бүхий үндсэн орон тооны профессор багш, докторын зэрэгтэй эрдэм шинжилгээний ажилтны дэвшүүлсэн төслийг;
- 2.1.9 “Өндөр түвшний судалгааны төсөл” гэж судалгааны ажлын үр дүнг WoS (Q1, Q2), эсвэл Scopus (Q1, Q2)-т бүртгэлтэй олон улсын мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлэх, МУИС-ийн нэр дээр оюуны өмчийн эрх авах зорилго бүхий энэ журмын 1.4-т дурдсан профессор багш, докторын зэрэгтэй эрдэм шинжилгээний ажилтны дэвшүүлсэн төслийг;

- 2.1.10 “Инновацийн төсөл” гэж МУИС-ийн нэр дээр батлагдсан оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах, гарааны компани байгуулах, лицензийн гэрээ хийх зорилго бүхий үйл ажиллагааг санхүүжүүлэх төслийг;
- 2.1.11 “Зочин судлаачийн төсөл” гэж МУИС-ийн үндсэн орон тооны профессор, дэд профессор, ахлах багш, багш, докторын зэрэгтэй эрдэм шинжилгээний ажилтан нар судалгааны чиглэлээр гэрээ байгуулж, гадаадын их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагаас ирж, хамтран ажиллах, лекц унших профессорын судалгааны ажилтай холбоо бүхий төслийг;
- 2.1.12 “Бодлогын судалгааны төсөл” гэж улс орны болон МУИС-ийн бодлогын тулгамдсан асуудал болон хэрэгжилтийг судлан шинжилж, асуудлыг шийдвэрлэх, хамгийн үр дүнтэй бодлогын сонголтуудыг тодорхойлж, сонголтын эерэг, сөрөг нөлөөллийг үнэлж, дүгнэсэн шийдлийн хувилбарыг санал болгох төслийг.

ГУРАВ. Судалгааны зарчим

3.1 Судалгааны үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

- 3.1.1 эрдмийн эрх чөлөөг дээдлэх;
- 3.1.2 шинжлэх ухааны нэгдмэл үнэт зүйлтэй байх;
- 3.1.3 судалгааны ёс зүйтэй байх;
- 3.1.4 шударга өрсөлддөг;
- 3.1.5 байгалийн ухаан, инженер технологи, нийгэм ба хүмүүнлэгийн ухааны салбаруудад хүртээмжтэй байх;
- 3.1.6 инновацын үйл ажиллагаанд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг тэгш эрхтэй, чөлөөтэй оролцуулах;
- 3.1.7 үндэсний аюулгүй байдал, хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх инновацын үйл ажиллагааг дэмжихгүй байх;
- 3.1.8 төрийн болон албаны нууцад хамаарахаас бусад эрдэм шинжилгээний ажил, түүний шалгаруулалт нь чөлөөт өрсөлдөөнд үндэслэсэн ил тод, шударга, нээлттэй байх;
- 3.1.9 сургалт, судалгааны үр дүн нь үйлдвэрлэгчийг дэмжсэн, эдийн засаг, нийгмийн өндөр үр ашигтай байх.

ДӨРӨВ. Судалгааны зардал

4.1 Бүрэлдэхүүн/салбар сургуулийн эрдэм шинжилгээний Б цагийн ажлын хэсгийн дүгнэлтэд үндэслэн Б цагаа бүрэн биелүүлсэн МУИС-ийн профессор, дэд профессор, докторын зэрэгтэй ахлах багшид судалгааны зардлыг тухайн хичээлийн жилд гарсан МУИС-ийн ректорын 01 тушаалыг үндэслэн олгоно.

4.2 Судалгааны зардал нь дараах хэлбэртэй:

- 4.2.1 судалгааны суурь зардал;

4.2.2 судалгааны хувьсах зардал;

4.2.3 лабораторийн суурь зардал.

4.3 Судалгааны суурь зардлыг дараах шаардлагыг бүрэн хангасан багшид олгоно.
Үүнд:

4.2.4 Бүрэлдэхүүн/салбар сургуулийн эрдэм шинжилгээний Б цагийг тооцох ажлын хэсгийн дүгнэлтэд үндэслэн Б цагаа бүрэн биелүүлсэн МУИС-ийн профессор, дэд профессор багш;

4.2.5 Ахлах багшийн зэрэглэлд ажиллаж буй, докторын зэргээ 5 хүртэл жилийн өмнө хамгаалсан багш;

4.2.6 МУИС-ийн удирдах албан тушаалд ажиллаж буй докторын зэрэгтэй багш;

4.2.7 Өмнөх жилийн судалгааны зардлаа бүрэн тайлагнаж, бүрэлдэхүүн/салбар сургуулийн захиргааны зөвлөлөөр суурь зардлыг олгохыг зөвшөөрч, энэ журмын 4.6-4.7-д дурдсан шаардлага хангасан багш.

4.4 Профессор, дэд профессор, докторын зэрэгтэй ахлах багш нь судалгааны суурь зардлыг мэдүүлэхдээ төслийн менежментийн систем (project.num.edu.mn)-ийн профессорын зардал цэсийн “Миний зардал” хэсгээс бүртгэлийн дугаар авч, зардлын задаргаа, хүлээгдэх үр дүнг оруулна.

4.5 Зардлыг энэ журмын 4.4-т мэдүүлсний дагуу зарцуулж, санхүүгийн холбогдох баримт, гүйцэтгэсэн үр дүнг ТММС-д байршуулан баталгаажуулна.

4.6 Өмнөх жилийн судалгааны суурь зардлын зарцуулалтаа ТММС-д бүрэн оруулж, баталгаажуулаагүй тохиолдолд тухайн жилд судалгааны суурь зардал олгохгүй.

4.7 Гүйцэтгэсэн үр дүнг бүрэлдэхүүн/салбар сургуулийн ажлын хэсэг баталгаажуулж, дараа жилийн суурь зардал олгох эсэхийг бүрэлдэхүүн/салбар сургуулийн захиргаа шийдвэрлэнэ.

4.8 Судалгааны суурь зардлын санхүүгийн тооцоо, гүйцэтгэсэн үр дүнг бүрэлдэхүүн/салбар сургууль хоёр жил тутамд ректорын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.

4.9 Судалгааны хувьсах зардал нь ахисан түвшний суралцагч тус бүрийн эрдэм шинжилгээний ажлын багц цагийн 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн дүн байна.

4.9.1 Удирдагч багшийн өмнөх хичээлийн жилд удирдаж хамгаалуулсан суралцагчдын эрдэм шинжилгээний ажлын дараах үзүүлэлтүүдээс аль нэгийг харгалзан тооцож, давхардуулахгүй олгоно:

4.9.1.1 WoS, Scopus-т бүртгэл бүхий мэргэжлийн сэтгүүлд нэгдүгээр, эсвэл холбоо барих зохиогчоор өгүүлэл хэвлүүлсэн бол бүтнээр;

4.9.1.2 WoS, Scopus-т бүртгэл бүхий мэргэжлийн сэтгүүлд хамтран зохиогч болон 5-аас доошгүй улсын судлаачид оролцсон олон улсын эрдэм шинжилгээний хуралд нэгдүгээр, эсвэл холбоо барих зохиогчоор аман илтгэл хэлэлцүүлсэн бол 75%;

4.9.1.3 мэргэжлийн түвшинд хянан магадалгаа хийгддэг дотоодын эрдэм шинжилгээний сэтгүүлд нэгдүгээр, эсвэл холбоо барих зохиогчоор өгүүлэл хэвлүүлсэн бол 50%;

4.9.1.4 улсын хэмжээний эрдэм шинжилгээний хуралд нэгдүгээр, эсвэл холбоо барих зохиогчоор аман илтгэл хэлэлцүүлсэн бол 25%.

4.10. **Лабораторийн суурь зардлыг** тухайн хичээлийн жилд үр дүнтэй, тогтмол үйл ажиллагаа явуулдаг судалгааны лабораторийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор олгоно.

4.11. Лабораторийн суурь зардлыг судалгааны лабораторийн судалгаа, инновацын үйл ажиллагаанд зарцуулна.

4.12. Энэ журмын 4.2-д заасан зардлуудыг профессор багшийн цалин, хөлсөнд зарцуулахыг хориглох ба дараах зүйлд зарцуулахыг зөвшөөрнө:

4.12.1 олон улсын мэргэжлийн сэтгүүл, нэг сэдэвт бүтээл, монографт бүтээл хэвлүүлэх;

4.12.2 ном, сурах бичиг, гарын авлага хэвлүүлэхэд нийт санхүүжилтийн 30 хүртэлх хувийг зарцуулах;

4.12.3 багаж төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилготой бүрдэл хэсэг, эд анги, материал, мэргэжлийн ном, сэтгүүл өгүүлэл, программ хангамж худалдан авах;

4.12.4 оюутны ажлын хөлс, тэтгэлэг;

4.12.5 лабораторийн судалгаа;

4.12.6 хээрийн судалгаа;

4.12.7 эмпирик судалгаа;

4.12.8 үндэсний болон олон улсын хурал, семинар, симпозиумд оролцох, зохион байгуулах, эдгээр үйл ажиллагаанд судлаачийг гадаадаас урьж оролцуулах.

ТАВ. Залуу судлаачийн төсөл

5.1 Төслийг 40 хүртэлх насны багшид нийт 2 удаа олгоно.

5.2 Залуу судлаачийн төслийн үр дүнгээр WoS, Scopus-т бүртгэлтэй мэргэжлийн сэтгүүлд нэгдүгээр, эсвэл холбоо барих зохиогчоор өгүүлэл хэвлүүлнэ. WoS, Scopus-т бүртгэлтэй мэргэжлийн сэтгүүлд хэвлэхийг зөвшөөрсөн (accepted) өгүүлэл, мөн МУИС-ийн нэр дээр батлуулсан оюуны өмч (патент)-ийг дүйцүүлэн тооцож болно.

5.3 Санхүүжилтийг цалин, ажлын хөлсөнд зарцуулахыг хориглох ба дараах зүйлд зөвшөөрнө:

5.3.1 Багаж төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилготой бүрдэл хэсэг, эд анги, материал, мэргэжлийн ном, сэтгүүл өгүүлэл, программ хангамж худалдан авах;

5.3.2 олон улсын мэргэжлийн сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх;

5.3.3 оюуны өмч мэдүүлэх;

5.3.4 төслийн судалгааны гишүүнээр ажиллаж буй оюутанд сургалтын тэтгэлэг олгох;

5.3.5 лабораторийн судалгаа;

5.3.6 хээрийн судалгаа;

5.3.7 судалгааны ажлын үр дүнгийн олон нийтэд түгээн дэлгэрүүлэх.

5.4 Санхүүжилтийг судалгааны ажлын туршлага, судалгааны ажлын үр дүнгээр WoS, Scopus-т бүртгэлтэй сэтгүүл болон бусад бүтээлд хэвлүүлэх, оюуны өмч бий болгох, салбар дундын судалгааг эхлүүлэх, хөгжүүлэх, суурь, хэрэглээний судалгааг эхлүүлэх зэргийг харгалзан олгоно.

5.5 Залуу судлаачийн төсөл олгох төслийн саналыг жил бүр зарласан хугацаанд ТММС-д цахим хэлбэрээр мэдүүлнэ.

ЗУРГАА. Суурь, хэрэглээний судалгааны төсөл

6.1 Суурь, хэрэглээний судалгааны төсөл нь шинжлэх ухааны онол, хэрэглээний арга зүйд тулгуурласан, үр дүнг практикт нэвтрүүлэх, хэрэглээнд ашиглах, эдийн засаг, нийгэм, байгаль орчны тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, шинэлэг технологи, бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, сайжруулах, шинэ арга, шийдэл нэвтрүүлэх зорилготой ба энэ төрлийн төслийг удирдагч багш, эрдэм шинжилгээний ажилтан нийт 2 удаа хэрэгжүүлнэ.

6.2 Төслийн үр дүнд WoS, эсвэл Scopus-т бүртгэлтэй олон улсын мэргэжлийн сэтгүүлд судалгааны өгүүлэл хэвлүүлнэ. МУИС-ийн нэр дээр батлуулсан дотоод, эсвэл гадаадын оюуны өмчийн эрх, патентыг дүйцүүлж болно. Харин нийгэм, хүмүүнлэгийн ухааны салбарын төслийн хувьд судалгааны үр дүнг Scopus-т бүртгэлтэй мэргэжлийн сэтгүүл, эсвэл олон улсын хэвлэлийн (SPI) индекс болон Scopus-т бүртгэлтэй хэвлэлийн газраас эрхлэн гаргадаг монограф, эсвэл номын цувралд нэгдүгээр, эсвэл холбоо барих зохиогчоор бүтээл хэвлүүлнэ. Хэвлэхээр зөвшөөрөгдсөн (accepted) бүтээлийг үр дүнд тооцож болно.


6.3 Санхүүжилтийг цалин, ажлын хөлсөнд зарцуулахыг хориглох ба дараах зүйлд зарцуулахыг зөвшөөрнө:

6.3.1 багаж төхөөрөмж, түүний хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилготой бүрдэл хэсэг, эд анги, материал, мэргэжлийн ном, сэтгүүл өгүүлэл, программ хангамж худалдан авах, лицензийн төлбөр;

6.3.2 төслийн судалгааны гүйцэтгэгчид олгох сургалтын тэтгэлэг;

6.3.3 лабораторийн судалгаанд зарцуулах, эсвэл тусгай тоног төхөөрөмж ашиглан туршилт хийх гадаад томилолт;

- 6.3.4 хээрийн судалгаа;
- 6.3.5 эмпирик судалгаа;
- 6.3.6 өгөгдөл цуглуулах;
- 6.3.7 оюуны өмч мэдүүлэх;
- 6.3.8 олон улсын мэргэжлийн сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх, олон улсын хэвлэлийн (SPI) индекс болон Scopus-т бүртгэлтэй хэвлэлийн газраас гаргадаг монограф, эсвэл номын цувралд бүтээл хэвлүүлэх.



- 6.4 Төслийн санал дэвшүүлэгч нь хүлээгдэж буй үр дүн, санхүүжилтийн хэмжээг 1 жилээр тооцож, төслийн мэдүүлэгтээ тодорхой тусгана.
- 6.5 Төслийн саналыг жил бүрийн зарласан хугацаанд ТММС-д цахим хэлбэрээр мэдүүлсний дараа шалгаруулах үйл явц үргэлжилнэ.

ДОЛОО. Өндөр түвшний судалгааны төсөл

- 7.1 Өндөр түвшний судалгааны төслийн үр дүнд WoS-т бүртгэлтэй Q1, Q2, эсвэл Scopus-т бүртгэлтэй Q1, Q2 ангиллын сэтгүүлд нэгдүгээр, эсвэл холбоо барих зохиогчоор нэгээс доошгүй бүтээл хэвлүүлнэ. Хэвлэхээр зөвшөөрөгдсөн (accepted) бүтээл, эсвэл МУИС-ийн нэр дээр батлуулсан дотоод, эсвэл гадаадын патентыг дүйцүүлэн тооцож болно.
- 7.2 Санхүүжилтийг энэ журмын 6.3-т заасны дагуу зарцуулна.
- 7.3 Өндөр түвшний судалгааны төслийн удирдагч нь хүлээгдэж буй үр дүн, санхүүжилтийн хэмжээг 1 жилээр тооцож, төслийн мэдүүлэгтээ тодорхой тусгана.
- 7.4 Өндөр түвшний төслийн саналыг жил бүр зарласан хугацаанд ТММС-д цахим хэлбэрээр мэдүүлсний дараа шалгаруулах үйл явц эхэлнэ.

Найм. Инновацын төсөл

- 8.1 МУИС-ийн үндсэн орон тооны профессор багш, эрдэм шинжилгээний ажилтан харьяалах Эрдмийн зөвлөлийн шийдвэрийн үндсэн дээр төслийн шалгаруулалтад оролцоно.
- 8.2. Инновацын төсөл хэрэгжүүлэхэд дараах шаардлагыг биелүүлсэн байна:
 - 8.2.1 инновацын төслийн удирдагч нь МУИС-ийн эзэмшдэг оюуны өмчийн зохиогч байх;
 - 8.2.2 төслийн багийн сүүлийн 5 жилийн хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлын туршлага, үр дүнг харгалзан үзэх;
 - 8.2.3 Зарласан хугацаанд холбогдох бичиг баримт болон бүрэлдэхүүн/салбар сургуулийн эрдмийн зөвлөлийн шийдвэрийг төслийн саналын хамт ТММС-д мэдүүлэх.
- 8.3. Инновацын төслийн үр дүнд гарааны компани байгуулах, эсвэл технологийн лицензийн гэрээг МУИС-тай байгуулна.

8.4 Инновацийн төслийн үр дүнг түгээн дэлгэрүүлэх ажлыг Шинжлэх ухаан, технологийн Улаанбаатар парк хариуцна.

8.5 Санхүүжилтийг цалин, ажлын хөлсөнд зарцуулахыг хориглох ба дараах зардалд зөвшөөрнө:

8.5.1 багаж төхөөрөмж, түүний хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилготой бүрдэл хэсэг, эд анги, материал, мэргэжлийн ном, сэтгүүл өгүүлэл, программ хангамж худалдан авах, лицензийн төлбөр;

8.5.2 төслийн судалгаанд гүйцэтгэгчээр ажиллаж буй суралцагчдад сургалтын тэтгэлэг;

8.5.3 лабораторийн судалгаанд зарцуулах, эсвэл тусгай тоног төхөөрөмж ашиглан туршилт хийх гадаад, дотоод томилолт;

8.5.4 өгөгдөл цуглуулах, боловсруулах;

8.5.5 оюуны өмч мэдүүлэх;

8.5.6 гарааны компани байгуулах, эсвэл технологийн лицензийн гэрээтэй холбоотой зардал.

Ес. Зочин судлаачийн төсөл

9.1 Зочин судлаачийн төслийн санхүүжилтэд МУИС-тай хамтарсан судалгаа гүйцэтгэдэг гадаадын иргэд ба гадаадын их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад ажилладаг Монгол Улсын иргэд хамрагдана.

9.2 Зочин судлаачийн төслийн санхүүжилтийг түүнтэй хамтран ажиллах МУИС-ийн профессор багштай хийсэн гэрээгээр зохицуулах бөгөөд дараах хэлбэрээр зарцуулна:

9.2.1 зочин судлаачийн Монгол Улсад ирэх замын зардал;

9.2.2 Монгол Улс дахь судалгаа;

9.2.3 олон улсын мэргэжлийн сэтгүүлд өгүүлэл, олон улсын хэвлэлийн (SPI) индекс бүхий монограф, эсвэл Scopus-т бүртгэлтэй номын цувралд бүтээл хэвлүүлэх.

9.3 Зочин судлаачидтай хамтран ажиллаж буй МУИС-ийн профессор багшид нэмэгдэл цалин, хөлс олгохгүй.

9.4 Зочин судлаачийн судалгааны ажлын туршлага, мэдлэгийг МУИС-ийн эрдмийн хамт олонд хүртээмжтэй байх зорилгоор 1 багц цагаас доошгүй хичээл заана.

9.5 Төсөл нь дараах шаардлагуудын аль нэгийг хангасан байна:

9.5.1 WoS, Scopus-т бүртгэлтэй, Q1, Q2 ангиллын мэргэжлийн сэтгүүлд МУИС-ийн профессор багш нэгдүгээр, эсвэл холбоо баригч зохиогчоор өгүүлэл хэвлүүлэх (хэвлэхээр зөвшөөрөгдсөн (accepted) өгүүллийг үр дүнд тооцож болно);

- 9.5.2 Олон улсын хэвлэлийн (SPI) индекс бүхий монограф, эсвэл Scopus-т бүртгэлтэй номын цувралд МУИС-ийн профессор багштай хамтран нэгдүгээр, эсвэл холбоо баригч зохиогчоор бүтээл хэвлүүлэх (хэвлэхээр зөвшөөрөгдсөн (accepted) өгүүллийг үр дүнд тооцож болно).
- 9.6 Зочин судлаач авч ажиллуулах санал хүлээн авах тухай зарлах ажлыг эрдэм шинжилгээ хариуцсан нэгж олон улсын хэмжээнд зохион байгуулна.
- 9.7. Зочин судлаач нь төслийн саналаа англи, эсвэл монгол хэлээр бичиж, хамтран ажилладаг МУИС-ийн профессороор дамжуулан ТММС-д цахим хэлбэрээр мэдүүлэхээс гадна дараах материалыг заавал хавсаргасан байна:
- 9.7.1 зочин судлаачийн анкет;
 - 9.7.2 судлаачийн бүтээлийн жагсаалт;
 - 9.7.3 судлаачийн ORCID iD болон, H-индекс;
 - 9.7.4 хамтын ажиллагааны гэрээ, санамж бичиг.
- 9.8 Үнэлгээний ажлын хэсэг зочин судлаачийн ирүүлсэн төслийн саналыг дор дурдсан шалгуур үзүүлэлтээр шалгаруулна:
- 9.8.1 зочин судлаач нь WoS, Scopus-т бүртгэлтэй, Q1, Q2 ангиллын мэргэжлийн сэтгүүлд өгүүлэл, эсвэл олон улсын хэвлэлийн (SPI) индекс бүхий монограф, эсвэл номын цувралд бүтээл хэвлүүлдэг байх;
 - 9.8.2 зочин судлаачийн санал болгож буй судалгааны төслийн хэрэгжих боломж, ажлын төлөвлөгөө, үр дүн баталгаатай байх;
 - 9.8.3 МУИС-ийн оюутан, суралцагчдад хичээл заах төлөвлөгөөтэй байх;
 - 9.8.4 эрдэм шинжилгээний хамтын ажиллагааг цаашид тогтвортой үргэлжлүүлэх төлөвлөгөөний хүрээнд хамтарсан судалгааны төслийн санал боловсруулан хэрэгжүүлэх боломжтой байх.

Арав. Бодлогын судалгааны төсөл

- 10.1 Бодлогын судалгааны төслийн саналыг харьяалах бүтцийн нэгжээс дэвшүүлж, бүрэлдэхүүн/салбар сургуулийн Эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн төслийн саналыг зарласан хугацаанд ТММС-д цахим хэлбэрээр мэдүүлнэ.
- 10.2 Энэ төсөл нь Монгол Улсын хөгжлийн бодлогын тулгамдсан асуудлын шийдэл гаргахад чиглэсэн байна.
- 10.3 Бодлогын судалгааны төслийг дор дурдсан шалгуур үзүүлэлтээр сонгон шалгаруулна:
- 10.3.1 Монгол Улсын болон МУИС-ийн хөгжлийн бодлоготой уялдсан, цаг үеийн тулгамдсан асуудлын шийдвэрлэхэд чиглэсэн байх;

10.3.2 бодлогын судалгааг хэрэгжүүлэх шаардлага, үндэслэлийг тодорхойлсон байх;

10.3.3 орчин үеийн бодлогын судалгааны арга зүйг оновчтой сонгосон байх;

10.3.4 бодлогын судалгааны хэлбэр, онцлог, чанар хамрах цар хүрээг тусгасан байх;

10.3.5 тухайн асуудлын судлагдсан байдал, олон улсын туршлагыг дурдсан байх;

10.3.6 судалгааны үр дүнгийн талаарх төсөөлөл, үр дүнг ашигласнаар бий болох үр дагавар, нөлөөллийг тодорхойлсон байх;

10.3.7 тухайн салбарын судалгааны ажлын туршлагатай эрдэмтэн судлаачдаас судалгааны багийн гишүүд бүрдсэн байх;

10.3.8 үр дүнг нэвтрүүлэх, ашиглах чиглэлийг тодорхойлсон байх.

10.4 Бодлогын судалгааны төслийн санхүүжилтийн зардлыг дор дурдсан хэлбэрээр захиран зарцуулна:

10.4.1 судалгааны материал, ном сурах бичиг, мэргэжлийн сэтгүүл, өгүүлэл, программ хангамж худалдан авах;

10.4.2 өгөгдөл цуглуулах;

10.4.3 хэлэлцүүлэг, семинар, зохион байгуулах;

10.4.4 бичиг хэрэг;

10.4.5 төслийн судалгааны гишүүнээр ажиллаж буй МУИС-ийн суралцагчдад сургалтын тэтгэлэг;

10.4.6 судалгааны тайлан, үр дүнг хэвлүүлэх;

10.4.7 судалгааны үр дүнг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх.

10.5 Төслийн үр дүнд хүлээлгэн өгөх бодлогын судалгааны тайлан нь дараах шаардлагыг хангасан байна:

10.5.1 бодлогын тулгамдсан асуудлыг тодорхойлж хөндсөн, нарийвчлан судалсан байх;

10.5.2 судалгааны аргуудыг үр дүнтэй хэрэглэсэн байх;

10.5.3 тухайн асуудлыг шийдвэрлэх боломжтой арга замуудыг тодорхойлсон байх;

10.5.4 боломжит үр дүнг шинжилгээнд түшиглэн үнэлж, танилцуулсан байх;

10.5.5 бодлогын шийдлийн нийгэм, эдийн засгийн хамгийн сайн хувилбар гэдгийг үндэслэлтэйгээр нотолсон байх;

10.5.6 судалгааны ажлын тайланг МУИС-ийн Бодлогын судалгааны төвийн гаргасан тайлангийн загвар, агуулгын дагуу бичсэн байх;

10.5.7 нэр томьёоны тодорхойлолтыг хоёрдмол утгагүй, товч, оновчтой илэрхийлсэн байх.

АРВАН НЭГ. Төслийн сонгон шалгаруулалт, тайлан

- 11.1 МУИС-аас санхүүжүүлэх судалгааны төслүүдийг хичээлийн жилийн эхний сар (10 дугаар сарын 15-ны өдрөөс 11 дүгээр сарын 15-ны өдөр)-д зарлаж, сонгон шалгаруулалтыг нэг сар (11 дүгээр сарын 15-ны өдрөөс 12 дугаар сарын 15-ны өдөр)-ын хугацаанд хийж, шалгарсан төслүүдийн гэрээг 12 дугаар сарын 15-ны өдрөөс 25-ны өдрийн дотор байгуулж, үргэлжлэх хугацааг санхүүгийн жилээр тооцно.
- 11.2 Төслийн шалгаруулалтыг холбогдох мэргэжлийн шинжээчдээс бүрдсэн сонгон шалгаруулах ажлын хэсгийг төслийн төрөл бүрээр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/349 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Шинжээчийн жагсаалт шинэчлэн батлах тухай” журам болон МУИС-ийн Захирлын 2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн А/347 тоот тушаалаар баталсан “МУИС-аас санхүүжих дотоод төслийн саналд үнэлгээ хийх ажлын удирдамж”-ийн дагуу эрдэм шинжилгээ хариуцсан нэгж зохион байгуулна.
- 11.3 Өндөр түвшний судалгааны төслийн санхүүжилтийг шинээр эхлэх судалгаанд биш, харин тодорхой түвшинд анхдагч үр дүн гарсан судалгааны ажлыг дэмжих чиглэлд зарцуулна.
- 11.4 Энэ журмын 1.4-д дурдсан профессор багш, эрдэм шинжилгээний ажилтан нь МУИС-ийн санхүүжилттэй нэг төсөлд удирдагчаар, эсвэл гүйцэтгэгчээр жилд 1 удаа оролцоно.
- 11.5 Бүх төрлийн төслийн санхүүжилтийн гэрээг эрдэм шинжилгээ хариуцсан нэгж болон санхүү, хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн нэгжийн удирдлагатай байгуулна.
- 11.6 Төслийн удирдагч гэрээ байгуулсны дараа ТММС-д бүртгүүлснээр төслийн санхүүжилтийг зарцуулах эрх нээгдэнэ. Төслийн санхүүгийн зарцуулалтыг хийхдээ гүйлгээний утга хэсэгт тухайн төслийн дугаарыг заавал бичнэ.
- 11.7 МУИС-аас санхүүжих төслийн мэдээллийг ТММС-д зөвхөн төслийн удирдагч мэдүүлэх бөгөөд тухайн төслийн гишүүдийг бүрэн оруулах үүрэгтэй.
- 11.8 Төслийн удирдагч нь судалгааны гүйцэтгэл ба санхүүгийн зарцуулалтаа ТММС-д улирал бүр мэдүүлнэ. Эцсийн тайланг харьяалагдах эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлэн, хурлын шийдвэр, хавсралт материал болон бусад холбогдох баримт бичгүүдийн хамт ТММС-д 12 дугаар сарын 15-ны дотор оруулна.
- 11.9 Эрдэм шинжилгээ хариуцсан нэгж тайланг хянан магадалснаар төслийг хаах эсэхийг шийднэ.
- 11.10 Шалгарсан төслийн удирдагч нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээ байгуулахаас татгалзсан тохиолдолд уг удирдагч холбогдох шинжээчдийн ажлын хөлсийг төлж барагдуулна.

- 11.11 Төслийн сонгон шалгаруулалт, хэрэгжилт, үр дүнтэй холбоотой хүсэлт, гомдол, маргааныг холбогдох нэгжид бичгээр ирүүлэх бөгөөд тус гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 7 өдөрт багтаан эрдэм шинжилгээ хариуцсан нэгж хариуг хүргүүлнэ.
- 11.12. Төслийн удирдагч нь бүрэлдэхүүн/салбарын Эрдмийн зөвлөлийн хурлаар төслийн хугацаа сунгах асуудлыг хэлэлцүүлэх хүсэлтээ тухайн жилийн 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор хүргүүлж, шийдвэрийг эрдэм шинжилгээ хариуцсан нэгжид 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор цахим хэлбэрээр ирүүлнэ. Эрдмийн зөвлөлийн шийдвэрийг үндэслэн төсөл хэрэгжүүлэх хугацааг 1 жил хүртэлх хугацаагаар нэг удаа сунгаж болно.
- 11.13 МУИС-ийн судалгааны санхүүжилтээр хэрэгжсэн төслийн үр дүнд бий болсон оюуны өмчийн эрхийг МУИС эзэмшинэ. Хэрэв төсөл хэрэгжүүлэгч, эсвэл төсөлд хамтрагч бусад талаас оюуны өмчийн эрх эзэмшихтэй холбоотой санал, хүсэлт, гомдол гарвал эрдэм шинжилгээ хариуцсан нэгжийн удирдлага холбогдох шийдвэрийг гаргана.

АРВАН ХОЁР. Төслийн үр дүнг түгээх

- 12.1 Төслийн үр дүнг Эрдэм шинжилгээний мэдээллийн менежментийн систем (ЭШММС)-д оруулна.
- 12.2 Төслийн үр дүнг хэвлэн нийтлэхдээ МУИС-ийн санхүүжилттэй судалгааны төслийн төрөл болон дугаарыг талархал болон бусад хэсэгт заавал дурдана.

АРВАН ГУРАВ. Хүлээлгэх хариуцлага

- 13.1 Төслийн гэрээний хугацаа дуусахад төслийн үр дүн, тайланг эрдэм шинжилгээ хариуцсан нэгжид хүлээлгэн өгөөгүй нөхцөлд дор дурдсан хариуцлага хүлээнэ:
- 13.1.1 Төслийг хаах хүртэлх хугацаанд МУИС-ийн санхүүжилттэй судалгааны төсөл дахин мэдүүлэхгүй.
- 13.1.2 Төсөл санхүүжүүлэгчээс үл хамаарах шалтгаан, энэ журмын 14.1-д заасан нөхцөл үүссэнээр төслийн хэрэгжилт удаашрах, үр дүн нь гэрээнд заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах болон нөхөн төлүүлэх зардлын хэмжээг эрдэм шинжилгээ болон санхүү, төлөвлөлт хариуцсан нэгжийн удирдлага тогтоож, шийдвэрлэнэ.
- 13.1.3 Эрдэм шинжилгээ хариуцсан нэгжээс төслүүдэд үнэлгээ хийх ажлын хэсгийг гурван жил тутамд байгуулан, дүгнэлт гаргах ба уг дүгнэлтийг үндэслэн хэрэгжилт нь хангалтгүй төслийн зардлыг эргэн төлүүлэх асуудлыг ректорын зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ.
- 13.2 Энэ журмын 12.2-т заасан мэдээллийг хэвлүүлсэн бүтээлдээ дурдаагүй тохиолдолд төслийн үр дүнг тооцохгүй.

- 13.3 Гэрээний үүргээ биелүүлээгүй нөхцөлд санхүүжилт олгохгүй бөгөөд тухайн төслийг ТММС-д амжилтгүй хэрэгжсэн төлөвт эрдэм шинжилгээ хариуцсан нэгж шилжүүлнэ.
- 13.4 Удирдагч ба гүйцэтгэгч нь төслийн үр дүн болон судалгааны ажлыг гүйцэтгэх явцад судалгааны ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлэнэ.

АРВАН ДӨРӨВ. Бусад

- 14.1 Төслийн удирдагч нь судалгааг гүйцэтгэх хугацаанд үүсэх эрсдэл, давагдашгүй хүчин зүйл (МҮХАҮТ-ын Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл болон хүнд нөхцөл байдлын баталгаа гаргах журмын 1.2 заалт)-ээс шалтгаалсан үр дагаврыг тооцсоны үндсэнд уг эрсдэл, үр дагаврыг зохицуулах нөхцөлийг гэрээний хавсралт болгон батлуулж, төслийн багийн нэг гишүүнийг итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилж болно.
- 14.2 Төслийн багийн гишүүн зөвшөөрсөн тохиолдолд төслийн удирдагч гэрээг багийн гишүүнд шилжүүлж болох бөгөөд салбарын эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн байна. Эрх шилжүүлсэн багийн гишүүн удирдагчийн ижил эрх, үүрэгтэй.



Судалгааны санхүүжилтийн хэмжээ

№	Судалгааны ажлын төрөл	Олгох багш, төсөл, нэгж	Олгох санхүүжилтийн дээд хэмжээ (мянган төгрөг)
1	Судалгааны суурь зардал	Профессорын зэрэглэлд ажиллаж буй багш	2,000.0
		Дэд профессорын зэрэглэлд ажиллаж буй багш	1,500.0
		Ахлах багш, багшийн зэрэглэлд ажиллаж буй багш (докторын зэрэгтэй)	1,000.0
2	Лабораторийн суурь зардал	Судалгааны лаборатори	1,500.0
3	Залуу судлаачийн төсөл	Нэг төсөл	20,000.0
4	Суурь, хэрэглээний судалгааны төсөл	Нэг төсөл	25,000.0
5	Өндөр түвшний судалгааны төсөл	Нэг төсөл	40,000.0
6	Инновацын төсөл	Нэг төсөл	30,000.0
7	Зочин судлаачийн төсөл	Нэг төсөл	30,000.0
8	Бодлогын судалгааны төсөл	Нэг төсөл	20,000.0